

**“ТАВАНТОЛГОЙ ТҮЛШ” ХХК-ИЙН БАРУУН ҮЙЛДВЭРТ ЦАХИЛГААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ АУДИТ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР**

20... оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

1. Ажлын үндэслэл	Эрчим хүчний хэмнэдтийн тухай хууль /10 дугаар зүлийн 10.2.2./ Засгийн газрын 2019 оны 181 дугаар тогтоол
2. Ажлын удирдамж	Баруун үйлдвэрийн цахилгаан , дулааны эрчим хүчний хэрэглээний одоогийн нөхцөл байдал, норм стандартад нийцэж буй эсэх, үйлдвэрийн цахилгаан дулааны хэрэглээнд нөлөөлж буй хүчин зүйлс тэдгээрийг бууруулах арга зам, боломжууд
3. Ажлын үе шатууд	<ol style="list-style-type: none"><li>1. Үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцах</li><li>2. Тоног төхөөрөмжийн ажиллагаа, хувийн зарцуулалт хэрэглээнд судалгаа хийх</li><li>3. Барилга байгууламжийн эрчим хүчний хэрэглээ, хийцлэл, материалын шинж чанарт үнэлэлт өгөх</li><li>4. Үйлдвэрийн тоног төхөөрөмжинд хэмжилт туршилт хийх</li><li>5. ТЭЗҮ болон техникийн анхдагч мэдээлэл, хэмжилтийн үр дүнд үндэслэл тооцоо судалгаа хийх</li><li>6. Тооцоо судалгаанд үндэслэсэн дүгнэлт зөвлөмж өгөх</li></ol>
4. Ажлын бүрэлдэхүүн	– Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ одоогийн нөхцөл байдал, норм стандартад нийцэж буй эсэх, цахилгааны хэрэглээнд нөлөөлөж буй

	<p>хүчин зүйлс, тэдгээрийн бууруулах арга зам боломжууд</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нөлөөлөж буй хүчин зүйлс дээр тус бүр дээр тооцоо судалгаа хийн дүгнэлт зөвлөмж өгөх</li> </ul> <p>Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Үйлдвэр, агуулах, авто граж, ус дулаан дамжуулах байгууламж, гал тогоо, ахуйн байр болон оффисуудын барилгуудад дулааны эрчим хүчний хэрэглээнд үнэлэлт өгөх, Барилгын дулааны эрчим хүчний хэрэглээг бууруулах арга зам, хөрөнгө оруулалтын тооцоо гаргах</li> <li>2. Үйлдвэрийн цахилгаан хангамж тоног төхөөрөмжүүд дээрх эрчим хүчний алдагдалыг бууруулж, үр ашигтай найдвартай ажиллагааг хангах боломжууд</li> <li>3. Түлш хатаах хатаагчийн дулаан алдагдал, агаарын урсгалыг тооцоо, бүтээмжийг нэмэгдүүлэх арга зам, боломж хөрөнгө оруулалтын тооцоо судлагаа</li> <li>4. Гаргасан дүгнэлт зөвлөмжийн дагуу эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж, технологи нэвтрүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт, гарах үр ашиг болон эрсдэлийн тооцоо</li> </ol>
<p>5.Тавигдах шаардлага</p>	<p>Эрчим хүчний тухай хууль, бусад холбогдох журмын дагуу аудитын ажлыг гүйцэтгэж, гаргасан дүгнэлт зөвлөмж нь үйлдвэрийн тасралтгүй найдвартай ажиллагааг хангахуйц, эрсдэлгүй, хэрэгжиж болохуйц бодитой байх. Мөн ТАД, ААД, ГАУСД, ХАБЭА-н тухай хууль холбогдох дүрэм журам стандартд нийцсэн байх.</p>

6. Хяналт удирдлага	Эрчим хүчний аудитын ажлыг гүйцэтгэхдээ ажлын явцын гүйцэтгэл болон эцсийн тайланг захиалагч талд хэлэлцэн шийдвэрлэнэ.
7. Хөрөнгө оруулагч (захиалагч) байгууллага	“Тавантолгой түлш” ХХК
8. Хэрэгжих хугацаа	2024 оны 04-05-р сар
9. Хүлээгдэж буй үр дүн	<ul style="list-style-type: none"><li data-bbox="730 536 1401 654">– Баруун үйлдвэрийн цахилгаан, дулааны эрчим хүчний одоогийн хэрэглээнд үнэлэлт дүгнэлт гаргуулах</li><li data-bbox="730 694 1401 853">– Барилга байгууламжийн дулаан алдагдлыг тодорхойлож түүнийг бууруулах арга зам, хөрөнгө оруулалтын тооцоог тайланд тусгах</li><li data-bbox="730 893 1401 1096">– Эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж, шинээр нэвтрүүлэж буй техник, технологийг нэвтрүүлэхэд гарах үр дүн, шаардагдах хөрөнгө оруулалтын эдийн засгийн тооцоололыг гаргах</li><li data-bbox="730 1136 1401 1339">– Түлш хатаах хатаагчийн ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх агаарын урсгалыг сайжруулах, цахилгаан зарцуулалт бууруулах арга зам тооцоо судалгааг гаргах</li></ul>